

ХЯТАДЫН НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АЙЛЧЛАЛ

ШУА -ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн урилгаар БНХАУ-ын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Ази, Номхон далай судлалын хүрээлэнгийн захирал доктор, профессор Жан Юйянь нарын 3 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид энэ оны 9 дүгээр сарын 4-нөөс 12-ны хооронд Монгол Улсад айлчиллаа. Айлчлалын зорилго нь хоёр хүрээлэнгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол, Хятадын харилцаа, ялангуяа худалдаа эдийн засгийн харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв, тулгамдсан асуудлуудтай танилцах, цаашдын хамтарсан судалгаа, солилцоог нэмэгдүүлэх явдал байлаа.

Айлчлалын үеэр хоёр хүрээлэнгийн эрдэмтэд хамтран “Монгол-Хятадын харилцааны өнөөгийн байдал” сэдвээр дугуй ширээний уулзалт ярилцлага хийсэнд ихээхэн сэтгэл хангалуун байгаагаа Хятадын талын төлөөлөгчид илэрхийлсэн байна.

Энэхүү айлчлал нь Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академи, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу болсон бөгөөд цаашид энэ солилцоог тогтмолжуулах, тэгш солилцооны хэлбэрт оруулах сонирхолтой байгаагаа мөн хоёр талаас илэрхийлсэн болно.

Айлчлалын явцад төлөөлөгчид ГХЯ-ны Хөрш орнуудын газар, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг, Газрын тосны хэрэг эрхлэх газар, Түлш эрчим хүчний яамны харъяа Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв зэрэг холбогдох төр захиргааны байгууллага яам, агентлаг болон Стратегийн судалгааны хүрээлэн, Үндэсний хөгжлийн хүрээлэн зэрэг эрдэм шинжилгээний байгууллага, МУИС -ийн ОУХС төдийгүй, манай оронд үйл ажиллагаа явуулж буй Хятадын хөрөнгө оруулалттай томоохон компани, аж ахуйн нэгжийн нэг болох “Цайрт минерал”, “Петро Дачин” компаниар зочилсон нь айлчлалын үр дүнг илүү үр өгөөжтэй болгосон хэмээн Хятадын эрдэмтэд ихэд үнэлж байлаа.

Тус Ази, Номхон далай судлалын хүрээлэн нь 1988 онд Хятадын Нийгмийн ШУА-ийн харъяанд байгуулагдсан, 4 сектор, 8 төвтэй, 60 гаруй ажилтан, судлаачтай, Ази Номхон далайн бүс нутгийн чиглэлээр иж бүрэн судалгаа явуулдаг, Хятад улсад болон гадаад орнуудад ихээхэн нэр хүнд бүхий мэргэжлийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага юм. Тус хүрээлэнгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг <http://iaps.cass.cn/> вэб хуудаснаас авч болох ажээ.

*Мэдээ бэлтгэсэн Д.Золбоо (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан, магистр)*